



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/56

Мөрөн сум

2022 оны бизнес төлөвлөгөө,  
бүтэц, орон тоо батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2.1, 2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 75 дугаар тогтоол, "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 8.4.2, 8.4.3, аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөвсгөл Барилга Захиалагчийн Хяналтын Төв" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2022 онд ажиллах бизнес төлөвлөгөөг 1 дүгээр, бүтэц, орон тоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үйлдвэрийн газрын санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээ тайланг цаг тухайд нь аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажиллахыг "Хөвсгөл Барилга Захиалагчийн Хяналтын Төв" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал (Д.Батчулуун)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар  
сарын 15 өдрийн 1/5 дугаар захирамжийн  
1 дүгээр хавсралт



**" ХӨВСГӨЛ БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ТӨВ" ОНӨААТҮГ-ЫН 2022  
ОНД АЖИЛЛАХ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	ҮЗҮҮЛЭЛТ	НИЙТ /МЯН.ТӨГ/
<b>1</b>	<b>Нэг. Орлого</b>	
1	2021 оны байгууллагын харилцах дансны үлдэгдэл	11,425,427
2	2022 оны улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн хяналтын орлого	178,786,790
3	Сум орон нутагт хийгдэх захиалагчийн хяналтын орлого	68,875,000
4	Аймагт баригдаж байгаа барилга байгууламжид гэрээгээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх орлого	28,122,000
	<b>Орлогын дүн</b>	<b>287,209,217</b>
<b>2</b>	<b>Хоёр. Зардал</b>	
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	137,330,000
2	Урамшуулал	11,970,000
	<b>НИЙТ</b>	<b>149,300,000</b>
1	Нийгмийн даатгал /Ажил олгогч/	18,662,500
2	Албан томилолтын зардал	12,856,500
3	Бичиг хэргийн зардал	3,622,000
4	Хангамжийн материалын зардал	2,904,000
5	Шуудан, харилцаа холбооны зардал	3,001,000
6	Урсгал засвар /Машин /	3,730,000
7	Тээвэр, шатахууны зардал	12,575,900
8	Хөдөлмөр хамгаалалын зардал	1,920,000
9	Сургалтын зардал	5,835,000
11	Автомашины татвар, үзлэг оношилгоо	528,000
12	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал/Аудит/	1,220,000
13	Даатгал зардал	1,400,000
14	Багаж хэрэгсэл	15,940,000
15	Программ хангамж	3,150,000
15	Оффисийн өрөөний засвар	4,214,500
16	Компьютер , тоног төхөөрөмж	2,050,000
17	Тавилга эд хогшил	1,900,000
18	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	25,073,200
19	Түрээсийн зардал	11,100,000
	<b>Зардлын дүн</b>	<b>280,982,600</b>
<b>3</b>	<b>Гурав. Ашиг алдагдал</b>	<b>6,226,617</b>
	Татварын өглөг	4,397,008
<b>4</b>	<b>Дөрөв. Нийт Ашиг алдагдал</b>	<b>1,829,610</b>

Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар  
сарын 15 өдрийн 01/6 дугаар захирамжийн  
2 дугаар хавсралт



**"ХӨВСГӨЛ БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ТӨВ" ААТҮГ-ЫН 2022 ОНД  
АЖИЛЛАХ БҮТЭЦ, ОРОН ТОО**

№	Албан тушаал	Орон тоо	Сарын дундаж цалин
1	Захирал	1	1600000
Нэг. Инженерийн баг			
1.1	Ерөнхий инженер	1	1200000
1.2	Барилгын инженер	1	950000
1.3	Сантехникийн инженер	1	950000
1.4	Цахилгааны инженер	1	950000
1.5	Холбоо, дохиоллын инженер	1	750000
1.6	Авто замын инженер	1	950000
Хоёр. Захиргаа, аж ахуй нэгж			
2.1	Нягтлан бодогч	1	850000
2.2	Архив бичиг хэргийн ажилтан /нярав	1	650000
2.3	Жолооч	1	650000
2.4	Жолооч	1	650000
	<b>Дүн</b>	<b>11</b>	